



СУХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 20

Баруун-Урт

Г “ХАМТАРСАН БАГ” БАЙГУУЛАХ ТУХАЙ 1

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор ажиллах хамтарсан багийн доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хамтарсан багийн дарга: - Хууль зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:- Цагдаагийн газрын дарга

Гишүүд:- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга

Боловсрол соёлын газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Нэгдсэн эмнэлгийн дарга

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын хэлтсийн дарга

Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга

Хөдөлмөрийн хэлтсийн дарга

ХЭҮК-ын Сүхбаатар аймаг дахь ахлах мэргэжилтэн

Сумдын Засаг дарга нар

Хоёр: Хамтарсан багийн дүрмийг хавсралтаар баталсугай.

Гурав: “Хамтарсан баг”-ийн ажлыг хагас бүтэн жилээр төлөвлөн, хэрэгжүүлж ажиллахыг хамтарсан багийн ахлагч /Хууль зүйн хэлтсийн дарга/-д үүрэг болсугай.

Дөрөв: Хамтарсан багууд ажлаа шат шатны ИТХТ-ийн хурал, мөн шат шатны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулан дүгнүүлж байхыг даалгасугай.

ДАРГА:

П.МОНХЖАРГАЛ

